

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

"Дорнод Бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/51/СТА-ТӨҮГ

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	3
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	6
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10	Үйл ажиллагааны орлого, зарлагын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10-11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүү байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

### Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ  
СИСТЕМ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Г.ОТГОНБААТАР  
ТАНАА

2019.03.20 № 06/508  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

071310

## Үүрэг, хариуцлага

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1. Оршил

“Дорнод Бүсийн эрчим хүчний систем ТӨХК”-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус байгууллагын Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 28-наас эхэлж 2019 оны 03 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Бэст фортуна аудит” ХХК-ийн Ахлах аудитор Б.Нарангэрэл ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК 2018 оны санхүүгийн тайланг “Бэст фортуна аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/138 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн бөгөөд Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацааг 13 хоногоор хэтрүүсэн.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргагүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Дорнод Бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: “Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь хэрэглэгчийн хэрэгцээт цахилгаан, дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн хэвийн найдвартай хангах явдал гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: “Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх,
- Цахилгаан импортлох,
- Эрчим хүчний тоноглолд засвар туршилт хийх,
- Цахилгаан эрчим хүч, дулааны эрчим хүчний тоолуур, гүйдлийн трансформатор суурилуулах, засварлах

“Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн удирдлага дараах хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Компанийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Татварын багц хууль
- Нийгмийн даатгалын шимтгэлийн хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

“Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Veritech Accounting” онлайн програм хангамж ашигладаг байна.

“Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 20 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 17 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Энэ нь төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурийг нийт орлогоор сонгосон бол гүйцэтгэлийн шатанд төвийн бүсээс цахилгаан худалдан авалтын тариф өссөнөөс өндөр эрсдэл агуулсан байж болзошгүй гэж үзэн нийт зардлаар сонгов.

“Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны нийт зардал 44,406.9 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 444.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг эрсдэл дунд гэж үзэн 1 хувийг сонгох нь зүйтэй гэж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр 17 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 12 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 10 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### 2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 192.9 сая төгрөгийг дахин үнэлгээний гарзаар үйл ажиллагааны бус зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.  
Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв
2. Нүүрсний хэвийн хорогдол 45.2 сая төгрөгийг үйл ажиллагааны бус зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.  
Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв
3. Ахмад ажилтнуудад олгосон тэтгэмжээс суутгасан 1.1 сая төгрөгийн Хувь хүний орлогын албан татварыг кассын нярвын нэр дээр тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.  
Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын татварын тайланд залруулга хийлгэв.
4. Худалдан авах ажиллагааны гэрээ дүгнэсэн актгүй, материал нийлүүлэгчийн зарлагын баримтгүй 379.6 сая төгрөг, авлага, өглөг, урьдчилж төлсөн тооцооны дансаар дамжуулаагүй 1,977.3 сая төгрөгийн тооцоог дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд шууд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.  
Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв
5. Петро чайна Тамсаг ХХК-ийн 110 кВт-ийн шугамын ажлын орлогын 70 хувийг, зардлыг 100 хувь тайланд онд хүлээн зөвшөөрч бүртгэсэн 1,013.3 сая төгрөгийн зөрүү нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.  
Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв



Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

## 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

№	Шийдэл	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал		
		Тоо	Дүн	(сая төгрөгөөр) Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	11.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	4.8	
3	Албан шаардлага өгсөн	1	1,293.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
Дүн		0	1,308.9	

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### Асуудал 1: Зардалтай холбоотой асуудал

Шүүхийн шийдвэрээр ажлаас буруу халсан нь тогтоогдсон ажилтанд олгосон цалингийн нөхөн олговор 4.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд оруулан тооцсон нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д “этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” заалттай нийцэхгүй байна.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоов

#### Асуудал 2: Зардал, үнэ тарифтай холбоотой асуудал

Диспетчерийн үндэсний төвөөс “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-д 2018 оны 11,12 дугаар саруудад худалдсан 10,046,608 кВт/ цагийн цахилгаан эрчим хүчний тарифыг 2.3 дахин буюу 128.7 төгрөгөөр нэмэгдүүлж 1,293.0 сая төгрөгөөр зардал өсгөж, ашиг бууруулсан нь Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-д “эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдэл:** Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороонд албан шаардлага хүргүүлэх

#### Асуудал 3: Орлого, үнэ тарифтай холбоотой асуудал

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын 31-ний 56 тоот тогтоолоор Диспетчерийн үндэсний төвөөс худалдан авах цахилгааны кВт/ цагийн тарифийг 181.81 төгрөгөөр тогтоосон боловч уул уурхайн компаниудад нийлүүлж байгаа цахилгааны кВт/ цагийн тарифийг 2015 оноос хойш индексжүүлээгүй, дунджаар 155 төгрөгөөр мөрдүүлж байгаа нь Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-д “тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх”,

9.1.5-д “эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. **Шийдэл:** Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороонд албан шаардлага хүргүүлэх

#### **Асуудал 4: Зардал, цалин хөлстэй холбоотой асуудал**

Арга хэмжээ авагдсан ажиллагсдын цалингаас суутгал хийгээгүй, Гүйцэтгэх захирлын тушаалын заалтыг хэрэгжүүлээгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1-д “Ажил олгогч буюу түүний хууль ёсны төлөөлөгч, эрх олгогдсон албан тушаалтан нь хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн ажилтанд дор дурдсан хэлбэрийн сахилгын шийтгэлийг шийдвэр гаргаж ногдуулна”, 131.1.2-д “үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах” гэсэн заалтуудыг нягтлан бодогч зөрчсөн байна.

**Шийдэл:** Завсрын аудитаар зөвлөмж өгсний дагуу 1 ажилтны суутгалыг 2018 оны 12 дугаар сард, 2 ажилтны суутгалыг 2019 оны 2 дугаар сард хийлгэв.

#### **Асуудал 5: Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Байгууллагын хэмжээнд 44 газрын эрх эзэмшиж байгаа боловч 43 газрыг эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний 193 дугаар тогтоолын “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдэл:** Завсрын аудитаар зөвлөмж өгч санхүүгийн тайланд тусгуулав.

### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

1. Диспечерийн үндэсний төвөөс худалдан авах, уул уурхайн компаниудад худалдах цахилгаан эрчим хүчний тарифийн асуудал,

2. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр 717.4 мянган м.кв газрын эзэмших эрхийн үнэ 17,957.9 сая төгрөг, 102 ширхэг барилга барилга байгууламжийн үнэ 15,004.1 сая төгрөгөөр үнэлэгдснийг мэргэшсэн үнэлгээчин М.Эрхэмбаяр хянаж баталгаажуулсан асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

### **2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар Гүйцэтгэх захирал нь батлагдсан төлөвлөгөө, зорилтот түвшин түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

“Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 41,707.2 сая төгрөгийн орлого, 40,184.6 сая төгрөгийн зардлын төлөвлөгөө батлагджээ. Батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг А-6-1, А-6-2 маягтаар баримтжуулан харуулав.

Орлогын нийт гүйцэтгэл 45,367.5 сая төгрөг буюу 108,8 хувь, нийт зардал 45,292.1 сая төгрөг буюу 112.7 хувь, татварын дараах ашиг төлөвлөснөөс 455.1 сая төгрөгөөр бага гарсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад өссөн нь Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолоор төвийн бүсээс худалдан авч байгаа цахилгааны тарифийг 11,12 дугаар саруудад үндэслэлгүйгээр 2.3 дахин өсгөснөөс шалтгаалсан байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

“Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь мэдээллээ Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр оруулсан байна. Үүнд:

Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 24 мэдээлэл, бусад 36 мэдээлэл оруулж, PDF файлаар 391 баримт оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмж биелээгүй байна. Зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 80.0 хувьтай байна.

Энэ нь өмнөх тайлант онд актлагдсан машин худалдан борлогдоогүйтэй холбоотой зөвлөмж хэрэгжээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Дорнод Бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Зардалтай холбоотой асуудал**

##### **3.1.1. Илрүүлэлт**

Өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад ажилтнуудад 11.1 сая төгрөг, спортын арга хэмжээ болон Үйлдвэрчний эвлэлийн хороотой хийсэн хамтын гэрээнд заасан олговорт 6.2 сая төгрөгийн зардлуудад захирлын тушаал болон төсөв гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.”Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтай нийцэхгүй байна

##### **3.1.2. Эрсдэл**

Дотоод хяналтыг сулруулах, хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

##### **3.1.3. Зөвлөмж**

Ажиллагсад олгож байгаа шагнал урамшуулал, буцалтгүй тусламж, тэтгэмжийн зардалд татвар орсон дүнгээр захирлын тушаал гаргаж байх, урлаг, спортын арга хэмжээний зардалд төсөв батлуулж, гүйцэтгэлийн тайлан гаргуулж хэвших, анхан шатны баримтын бүрдлийг хангуулах

##### **3.1.4. Байгууллагаас ирүүлсэн хариу, тайлбар**

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,619,571,482.45</u></b>	<b><u>3,184,931,556.98</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	2,796,953,659.77	41,033,633.05
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	1,698,585.96	6,105,606.79
31110	Төгрөг	1,698,585.96	6,105,606.79
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	2,795,255,073.81	34,928,026.26
3121	Төгрөг	2,718,377,065.98	34,340,161.56
31213	Арилжааны банк дахь харилцах	2,718,377,065.98	34,340,161.56
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	76,878,007.83	587,864.70
31223	Арилжааны банк дахь харилцах	76,878,007.83	587,864.70
<b>32</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>321</b>	<b>Үнэт цаас</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	49,007,954.08	41,929,539.83
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,291,849.99	
33401	Дансны авлага /ТӨҮГ/	20,055,495.38	18,068,294.71
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	24,510,506.46	1,767,263.86
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,150,102.25	22,093,981.26
3351	Байгууллагаас авах авлага	2,150,102.25	22,093,981.26
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	2,078,999.66	1,014,548,554.22
34600	Урьдчилж гарсан зардал	2,078,999.66	1,014,548,554.22
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,380,048,486.89	1,694,558,105.13
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	23,510,674.81	31,541,624.62
35110	Тусгай зориулалттай материал	23,336,534.56	31,273,169.78
35130	Эм боох материал	174,140.25	268,454.84
35300	Бэлэн бүтээгдэхүүн	712,365,994.10	780,164,044.29
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	611,487,389.02	841,917,383.92
35420	Аж ахуйн материал	9,201,672.90	9,910,107.20
35430	Сэлбэг хэрэгсэл	507,185,722.89	704,633,140.15
35440	Түлш, шатах тослох материал	26,210,666.98	45,880,508.80
35450	Барилгын засварын материал	37,581,607.44	41,499,164.12
35470	Бусад хангамжийн материал	31,307,718.81	39,994,463.65
35600	Мал амьтад	32,684,428.96	40,935,052.30
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	391,482,382.05	392,861,724.75
36600	Бусад нөөц	391,482,382.05	392,861,724.75
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>62,959,638,983.45</u></b>	<b><u>94,660,123,359.26</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	62,959,638,983.45	94,660,123,359.26
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	62,825,883,533.47	76,246,959,216.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	100,380,819,009.65	109,297,707,138.88

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

39202	Хуримтлагдсан элэгдэл	60,599,352,036.98	58,139,931,342.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,329,672,535.51	3,235,515,535.51
39204	Хуримтлагдсан элэгдэл	1,105,623,053.38	1,379,590,421.75
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	93,885,860,539.37	97,638,522,437.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	72,377,283,677.88	74,829,568,570.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	295,491,357.18	378,727,767.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	110,816,958.14	143,265,133.18
39214	Бусад үндсэн хөрөнгө	309,741,657.09	414,221,637.09
39215	Хуримтлагдсан элэгдэл	182,625,838.95	225,379,831.07
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	133,755,449.98	18,413,164,142.61
39301	Програм хангамж	202,915,716.23	239,308,716.23
39302	Хуримтлагдсан элэгдэл	84,873,763.96	145,676,151.24
39303	Бусад биет бус хөрөнгө	21,300,000.00	18,330,730,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	5,586,502.29	11,198,922.38
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>67,579,210,465.90</u></b>	<b><u>97,845,054,916.24</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>16,694,442,913.29</u></b>	<b><u>17,959,372,462.95</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,012,485,330.90	3,648,122,110.53
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,974,084,864.24	3,430,123,935.53
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,974,084,864.24	3,430,123,935.53
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	954,581,698.86	-
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	543,347,053.65	255,207,652.47
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	476,156,111.73	3,174,916,283.06
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	38,400,466.66	217,998,175.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	38,400,466.66	217,998,175.00
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	14,681,957,582.39	14,311,250,352.42
<b>422</b>	<b>Урт хугацаат зээл</b>	14,681,957,582.39	14,311,250,352.42
<b>4221</b>	<b>Төгрөг</b>	9,412,193,019.81	9,289,415,109.01
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	9,412,193,019.81	9,289,415,109.01
<b>4222</b>	<b>Гадаад валют</b>	5,269,764,562.58	5,021,835,243.41
42230	Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	5,269,764,562.58	5,021,835,243.41
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>50,884,767,552.61</u></b>	<b><u>79,885,682,453.29</u></b>
51101	Өмч: - төрийн	47,984,200,655.36	47,984,200,655.36
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		18,322,781,888.30
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,665,180,749.92	2,167,665,413.67
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,265,567,825.51)	1,272,532,399.92
51220	Тайлант үеийн үр дүн	3,930,748,575.43	895,133,013.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,235,386,147.33	11,411,034,495.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>67,579,210,465.90</u></b>	<b><u>97,845,054,916.24</u></b>

## 4.2 АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>42,479,925,171.95</b>	<b>45,302,057,951.28</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>42,479,925,171.95</b>	<b>45,302,057,951.28</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	42,479,925,171.95	45,302,057,951.28
120002	Хүүгийн орлого	264,862,182.50	159,142,146.87
120005	Түрээсийн орлого	32,466,387.39	37,568,581.82
120009	Бусад орлого	875,316,811.58	3,482,567,687.65
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	41,307,279,790.48	41,622,779,534.94
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	26,386,943,214.41	29,073,750,307.97
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>38,321,589,804.93</b>	<b>44,248,276,696.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>38,321,589,804.93</b>	<b>44,248,276,696.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	38,321,589,804.93	44,248,276,696.80
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	38,321,589,804.93	44,248,276,696.80
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	8,327,402,022.39	8,899,064,165.01
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	1,536,846,497.69	1,697,233,335.07
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	89,352,772.45	95,402,889.44
210813	Бусад зардал /ТӨҮГ/	1,443,608,516.53	4,289,967,648.05
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	537,436,781.46	192,858,351.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>4,158,335,367.02</u></b>	<b><u>1,053,781,254.48</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	231,851,850.13	158,648,240.73
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	231,851,850.13	158,648,240.73
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(231,851,850.13)	(158,648,240.73)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>3,926,483,516.89</u></b>	<b><u>895,133,013.75</u></b>

### 4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>46,675,471,209.53</u></b>	<b><u>45,633,272,304.69</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>46,675,471,209.53</b>	<b>45,633,272,304.69</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	46,675,471,209.53	45,633,272,304.69
120009	Бусад орлого	857,796,926.55	308,220,313.04
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	45,737,968,178.98	45,163,888,343.65
120015	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/	79,706,104.00	161,163,648.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>36,021,260,124.41</u></b>	<b><u>36,970,404,720.99</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>36,021,260,124.41</b>	<b>36,970,404,720.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>36,021,260,124.41</b>	<b>36,970,404,720.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	8,859,351,851.63	10,368,234,389.74
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	8,859,351,851.63	10,368,234,389.74
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,546,440,472.33	3,003,784,137.14
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	2,546,440,472.33	3,003,784,137.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	52,200,907.87	268,535,499.51
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	52,200,907.87	268,535,499.51
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,781,635,281.47	17,660,872,660.06
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	9,922,283,429.84	8,448,653,166.23
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	8,859,351,851.63	9,212,219,493.83
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,781,631,611.11	5,668,978,034.54
210815	Хүүний төлбөрт төлсөн /ТӨҮГ/	183,217,616.74	95,402,889.44
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	3,970,594,290.06	4,161,996,280.78
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	139,521,368.00	199,973,190.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	1,488,298,336.31	1,211,605,674.32
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>10,654,211,085.12</u></b>	<b><u>8,662,867,583.70</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-



“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>584,688,424.00</b>	<b>3,333,237,580.84</b>
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	4,000,000.00	11,008,826.00
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	315,826,241.50	-
140006	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		3,163,086,607.97
140007	Хүлээн авсан хүүний орлого	264,862,182.50	159,142,146.87
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,484,083,137.64</b>	<b>13,898,697,208.11</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,484,083,137.64</b>	<b>13,898,697,208.11</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	6,448,083,137.64	10,383,789,169.75
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	36,000,000.00	29,911,000.00
225103	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		3,484,997,038.36
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	-	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(5,899,394,713.64)</u></b>	<b><u>(10,565,459,627.27)</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	-	-
<b>25</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>	<b>2,025,547,122.65</b>	<b>853,327,983.15</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	(173,223,104.31)	(16,938,978.23)
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,112,688,442.96	430,910,848.32
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		46,707,763.06
250004	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
250005	Төлсөн ногдол ашиг	1,086,081,784.00	392,648,350.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>(2,025,547,122.65)</u></b>	<b><u>(853,327,983.15)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>2,729,269,248.83</b>	<b>(2,755,920,026.72)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>67,684,410.94</b>	<b>2,796,953,659.77</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,796,953,659.77</b>	<b>41,033,633.05</b>

#### 4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Төрийн өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	43,299,042,917.54	594,909,324.88	85,723,821.03	-1,179,486,041.51	42,800,190,021.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>43,299,042,917.54</b>	<b>594,909,324.88</b>	<b>85,723,821.03</b>	<b>-1,179,486,041.51</b>	<b>42,800,190,021.94</b>
Зарласан ногдол ашиг				-1,086,081,784.00	-1,086,081,784.00
Өмчид гарсан өөрчлөлт	4,685,157,737.82	644,741,880.99	-85,723,821.03		5,244,175,797.78
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-4,265,058.54		4,265,058.54	0.00
Тайлант үеийн үр дүн				3,926,483,516.89	3,926,483,516.89
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>47,984,200,655.36</b>	<b>1,235,386,147.33</b>	<b>0.00</b>	<b>1,665,180,749.92</b>	<b>50,884,767,552.61</b>
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>47,984,200,655.36</b>	<b>1,235,386,147.33</b>	<b>0.00</b>	<b>1,665,180,749.92</b>	<b>50,884,767,552.61</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>47,984,200,655.36</b>	<b>1,235,386,147.33</b>	<b>0.00</b>	<b>1,665,180,749.92</b>	<b>50,884,767,552.61</b>
Зарласан ногдол ашиг				-392,648,350.00	-392,648,350.00
Өмчид гарсан өөрчлөлт		10,193,488,516.22	18,322,781,888.30		28,516,270,404.52
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		-17,840,167.59			-17,840,167.59
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
Тайлант үеийн үр дүн				895,133,013.75	895,133,013.75
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>47,984,200,655.36</b>	<b>11,411,034,495.96</b>	<b>18,322,781,888.30</b>	<b>2,167,665,413.67</b>	<b>79,885,682,453.29</b>

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Диспетчерийн үндэсний төвөөс худалдан авсан 10,046,608 кВт/цагийн цахилгаан эрчим хүчний тарифыг 2.3 дахин буюу 128.7 төгрөгөөр өсгөсөн, уул уурхайн компаниудад нийлүүлж байгаа цахилгааны үнэ тарифийг 2015 оноос хойш индексжүүлээгүй.	1,293.0	Албан шаардлага өгсөн	Эрчим хүчний сайд	
2	Өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад ажилтнуудад 11.1 сая төгрөг, Үйлдвэрчний эвлэлийн хороотой хийсэн хамтын гэрээнд заасан олговорт 6.2 сая төгрөг, спортын арга хэмжээний 8.7 сая төгрөгийн зардлуудад захирлын тушаал болон төсөв гаргаагүй.	11.1	Зөвлөмж өгсөн	Гүйцэтгэх захирал	Г.Отгонбаатар
3	Шүүхийн шийдвэрээр ажлаас буруу халсан нь тогтоогдсон ажилтанд олгосон цалингийн нөхөн олговор 4.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд оруулан тооцсон нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д “этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” заалттай нийцэхгүй байна.	4.8	Төлбөрийн акт тавив	Гүйцэтгэх захирал	Г.Отгонбаатар
	<b>Дүн</b>	<b>1,308.9</b>			

